



МОНГОЛЫН ЗАЛУУ ЭРДЭМТДИЙН ХОЛБОО

Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Бага тогтруу 1, Ерөнхий сайд
А.Амарын гудамж 1, С.ТӨ. "Г" корпус, 7 давхар 710 тоот
Монгол улс, Улаанбаатар-14200
Утас: +(976)-99716151; +(976)-99057680
Цахим хаяг: <http://www.mysa.mn>,
Цахим шуудан: info@mysa.mn, mysa@gmail.com

2018.09.10 № 16
танай _____ № _____ -т

ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ

Эрдэм шинжилгээний бага хуралд оролцуулах тухай

Юуны өмнө Монголын залуу эрдэмтэн судлаачдын бүтээлч үйл ажиллагааг дэмжин ажилладаг та бүхэнд талархал илэрхийлье. Монголын залуу эрдэмтдийн холбооноос 2018 оныг Мэдлэгийг Монголдоо нутагшуулах зорилтыг хэрэгжүүлэн “Brain Drain to Brain Gain” бодлогыг санаачлан хэрэгжүүлэхээр зорин ажиллаж байгааг та бүхэндээ дуулгахад таатай байна.

Боловсрол Соёл Шинжлэх Ухааны сайдын 2010 оны 07 дугаар сарын 01-ний 324 дүгээр тушаалаар батлагдсан “Сайдын нэрэмжит грант олгох журам”-ын дагуу Монголын Залуу Эрдэмтдийн Холбооноос залуу эрдэмтэн судлаачдыг хамруулсан “Хүрэлтогоот-2018” эрдэм шинжилгээний бага хурлыг шинжлэх ухааны 7 салбараар БСШУСЯ, ШУА, ШУТС-тай хамтран 2018 оны 10 дугаар сарын 06-ны өдрөөс 10 дугаар сарын 27-ны өдрийн хооронд зохион байгуулахаар ажиллаж байна.

“Хүрэлтогоот” эрдэм шинжилгээний бага хурал нь Монгол улсын шинжлэх ухаан, технологийн салбарын залуу эрдэмтэн судлаач нарт судалгааны үр дүн, бүтээлээ хэлэлцүүлэх боломж олгох улмаар дэмжлэг хүртэх, тухайн салбарын хүний нөөцийг чадавхижуулан эрдэмтдийн залгамж халааг бэлтгэх дэлхийн хэмжээний арга хэмжээ юм. “Хүрэлтогоот-2018” эрдэм шинжилгээний бага хуралд салбар тус бүрээр шилдэгээр шалгарсан хоёр залуу судлаачид БСШУС-ын сайдын нэрэмжит ГРАНТ (4 сая төгрөг)-ыг олгоно.


Иймд “Хүрэлтогоот-2018” эрдэм шинжилгээний бага хуралд өөрийн байгууллага, салбарын залуу судлаач, эрдэмтэн багш нарыг идэвхтэй оролцуулахыг хүсье.

“Хүрэлтогоот-2018” эрдэм шинжилгээний бага хурлын хуваарь болон хурлыг зохион байгуулах бүрэлдэхүүний мэдээллийг хавсралтаар хүргүүлж байна. Эрдэм

шинжилгээний бага хурлын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг www.khureltogoot.mysa.mn
хаягаас авна уу.

*Жич: Хурал зохион байгуулах комиссын гишүүдийн нэрс болон хурал болох өдрийн товыг
хавсралтаар хүргүүлж байна.*

ХҮНДЭТГЭСЭН,
ЕРӨНХИЙЛӨГЧ



Д. БАТТОГТОХ

